

## Mongolian A: literature – Standard level – Paper 2

### Mongol A: littérature – Niveau moyen – Épreuve 2

### Mongol A: literatura – Nivel medio – Prueba 2

Tuesday 1 May 2018 (morning)

Mardi 1 mai 2018 (matin)

Martes 1 de mayo de 2018 (mañana)

1 hour 30 minutes / 1 heure 30 minutes / 1 hora 30 minutos

---

#### Instructions to candidates

- Do not open this examination paper until instructed to do so.
- Answer one essay question only. You must base your answer on at least two of the part 3 works you have studied and compare and contrast these works in response to the question. Answers which are not based on a discussion of at least two part 3 works will not score high marks.
- You are not permitted to bring copies of the works you have studied into the examination room.
- The maximum mark for this examination paper is **[25 marks]**.

#### Instructions destinées aux candidats

- N'ouvrez pas cette épreuve avant d'y être autorisé(e).
- Traitez un seul sujet de composition. En basant votre réponse sur au moins deux des œuvres de la troisième partie que vous avez étudiées, vous devez comparer et opposer ces œuvres dans le cadre du sujet. Les réponses qui ne sont pas basées sur au moins deux des œuvres de la troisième partie n'obtiendront pas une note élevée.
- Vous n'êtes pas autorisé(e) à apporter des exemplaires des œuvres que vous avez étudiées dans la salle d'examen.
- Le nombre maximum de points pour cette épreuve d'examen est de **[25 points]**.

#### Instrucciones para los alumnos

- No abra esta prueba hasta que se lo autoricen.
- Conteste una sola pregunta de redacción. Base su respuesta en al menos dos de las obras estudiadas de la parte 3, comparándolas y contrastándolas en relación con la pregunta. Las respuestas que no se basen en al menos dos obras de la parte 3 no recibirán una puntuación alta.
- No está permitido traer copias de las obras estudiadas a la sala de examen.
- La puntuación máxima para esta prueba de examen es **[25 puntos]**.

Зөвхөн нэг асуултыг сонгон 3-р хэсгийн **доод тал нь** хоёр зохиолын **ижил төстэй болон ялгаатай зүйлүүдийг харьцуулан** эсээ бич. Хэрэв хариултаа 3-р хэсгийн доод тал нь хоёр зохиолд үндэслээгүй бол зохих оноогоо **авч чадахгүй** болохыг анхаар.

### **Жүжиг**

1. “Хошин жүжигт хүний сул талыг харуулдаг бол эмгэнэлт жүжигт хүч чадлыг дүрсэлдэг.” Доод тал нь хоёр жүжгийн зохиолчийн бүтээлийг сонгож, уг санаатай тохирч байгаа эсэхийг ажиглан талбарла.
2. Сонгон судалсан зохиолоосоо доод тал нь хоёр жүжгийн зохиолыг сонгож, гол дүрийн хөгжил ба өөрчлөлтийг дүрсэлсэн аргуудыг жишин харьцуул.
3. Судалсан зохиолоосоо доод тал нь хоёрыг сонгож, зохиолчид онцгой цаг мөчийн түгшүүртэй байдлыг дүрслэхийн тулд хэрэглэсэн хэл найруулгын арга хэрэглүүр болон үр дүнг харьцуулан тайлбарла.

### **Яруу найраг**

4. Уншиж судалсан зохиолоосоо доод тал нь хоёр яруу найрагчийн бүтээлийг сонгож, уншигчдын сэтгэлийг хөдөлгөхийн тулд үгийг хэрхэн оновчтой сонгосныг тайлбарла.
5. Таны сонгон судалсан зохиолоос доод тал нь хоёр яруу найрагчийн бүтээлд урам хугарах болон айх гэх мэт мэдрэмжийг ямар аргаар дүрсэлсэн байна вэ?
6. Доод тал нь хоёр яруу найрагчийн бүтээлийг сонгож, цаг хугацаа болон үүний үр дүнд нөлөөлөх байдлыг дүрсэлсэн арга маягийг жишин харьцуул.

### **Үргэлжилсэн үгийн зохиол**

7. Зохиолын үйл явдал нь заримдаа урьдчилан тааж болохоор байдаг бол заримдаа гэнэтийн байдаг. Сонгон судалсан зохиолоосоо доод тал нь хоёрыг сонгож, энэхүү санааг хэрхэн дүрсэлснийг тайлбарла.
8. Хүүрнэл зохиолд гол дүрүүдийн хөгжил чухал байдаг. Сонгон судалсан зохиолоосоо доод тал нь хоёрыг сонгож, дүрийг бүтээсэн арга хэрэглүүр болон үр дүнг харьцуул.
9. Сонгон судалсан зохиолоосоо доод тал нь хоёрыг сонгож, гол санаагаа тодруулахын тулд зохиолч егөөдлийг хэр зэрэг ашигласныг жишин харьцуул.

### **Баримтат зохиол**

10. Сонгон судалсан зохиолоосоо доод тал нь хоёрыг сонгож, өдөр тутмын амьдралын үйл явдал, байдал төрхийг зохиолч хэрхэн дүрсэлснийг тайлбарлан бич.
  11. Баримтат зохиол бол голчлон мэдээлэл түгээх шинжтэй байдаг. Сонгон судалсан зохиолоосоо доод тал нь хоёрыг сонгож, уг санааны үндэслэлтэй эсэхийг тайлбарла.
  12. Баримтат зохиолын бичигч нь өөрөө дүрийн загвар байдаг. Сонгон судалсан зохиолоосоо доод тал нь хоёрыг сонгож, уг санааны үндэслэлтэй эсэхийг тайлбарла.
-